



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 5 сарын 22 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монголын Ногоон Намаас Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 1 дүгээр тойрогт нэр дэвшүүлсэн Алтанхүүгийн Мандал нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4, 32.2.5, 32.2.6, 32.2.7, 32.2.8, 32.2.9-д заасан баримт бичгийг дутуу ирүүлсэн тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

